



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 4/19

Хархорин сум

Тамхи худалдах үйл ажиллагааг эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” 08/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Эрдэнэтолгой багийн Сайр 1-4 тоот хаягт байрлах “Ар булаг цохиот” ХХК (3573338)-ийн “Орхон” 8 нэрийн хүнсний дэлгүүрт тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгосугай.
2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, дэд хурандаа (Д.Отгонбаяр), Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Бямбасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100037